



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/179

Улаанбаатар хот

**“Дулаан Багахангай” аян зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгж, албан байгууллагууд, нийтийн орон сууц, гэр хорооллын айл өрхүүдийн өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, дулаан хэмнэлтийн зөв дадалд бүх нийтийг уриалах зорилгоор 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд “Дулаан Багахангай” аяныг зохион байгуулахыг дүүргийн Менежер (Г.Дагвадорж)-т үүрэг болгосугай.

2.Аяныг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар, зарцуулагдах хөрөнгийн төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тус аяныг зохион байгуулахад зарцуулагдах 1.250.000 (Нэг сая хоёр зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, иргэд, олон нийтэд сурталчлахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL/2024 он ажил/захирамж

1123200421

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 11 сарын 27 ны өдрийн 1117 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Г.Дагвадорж	Дүүргийн менежер
Гишүүд:	Д.Хүрэлбаатар	Тохижилт, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
	Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
	Д.Бужигдай	Хангай өргөө" Сууц өмчлөгчдийн холбооны захирал
	Л.Алтантөгс	"Баян хангай" Сууц өмчлөгчдийн холбооны захирал
	З.Нармандах	"Их хангай" Сууц өмчлөгчдийн холбооны захирал
Нарийн бичиг:	Б.Батхуяг	Тохижилт,худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 11 сарын 27 ны өдрийн 4117 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



“ДУЛААН БАГАХАНГАЙ” АЯНЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1.	“Дулаан Багахангай” аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулах, аж ахуйн нэгж байгууллага, хороодод хүргэх.	2024.11.04	Тохижилт худалдаа үйлчилгээний хэлтэс
2.	Орон сууцны болон гэр хорооллын айл өрхүүдийн өвөлжилтийн бэлтгэл хангасан эсэх талаарх судалгаа гаргах.	2024.11.01- 2024.11.08	ТХҮХ Хороод
3.	Аяны хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, нийтийн орон сууц, гэр хорооллын өрхүүдийн орон байрыг дулаалуулах арга хэмжээ зохион байгуулах	2024.11.08 2024.11.29	ЗДТГ Хороод Бүх аж ахуйн нэгж байгууллагууд
4.	Орон сууцны байрнуудын орцны хаалга, цонхыг дулаалах, подвалын цонхнуудыг битүүлэх	2024.11.07- 2024.11.15	“Хангай Өргөө” СӨХ “Их Хангай” СӨХ “Баян хангай” СӨХ
5.	Аж ахуйн нэгж, байгууллагууд ажилтан, албан хаагчдынхаа тодорхой хэсэгт, нүүрс, түлээний дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх	2024.11.01- 2024.11.29	Бүх аж ахуй нэгж, байгууллагууд,
6	Дүүргийн дэмжлэг, тусламж зайлшгүй шаардлагатай айл өрхөд, түлээ, нүүрсний туслалцаа үзүүлэх	2024.11.01- 2024.11.29	ЗДТГ
7	Аяны хүрээнд зохион байгуулсан ажлын тайлан, дүн мэдээг нэгтгэх	2024.12.05	Тохижилт худалдаа үйлчилгээний хэлтэс

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 12 сарын 01 ны өдрийн 1111 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт



“ДУЛААН БАГАХАНГАЙ” АЯНД
ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Санал
					Нийт үнэ
1	Нүүрс	тн	10	125,000	1,250,000
Дүн					1,250,000